



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/017-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsoqjargalb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 166

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТСҮХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,508,176.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,288,640.2 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 219,536.4 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Бага сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2025 онд аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 77.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	934,661.24	1,117,591.79
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	396,116.72	548,290.29
1.1.3 АВЛАГА	383,985.39	357,592.87
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	72,695.13	141,401.63
1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	81,864	70,307
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,024,237.74	7,314,926.01
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,024,237.74	7,314,926.01
1.2.2.02 Биет хөрөнгө	2,003,306.74	7,284,022.51
1.2.2.03 Биет бус хөрөнгө	20,931	30,903.5
1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,958,898.99	8,432,517.8
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	99
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	99
2.1.1.03 Өглөг	0.0	99
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,958,898.99	8,432,418.8
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,958,898.99	8,432,418.8
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	496,878.33	496,878.33
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,163,321.03	7,636,840.84
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,699.63	298,699.63
2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,958,898.99	8,432,517.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,779,511.88	8,335,544.5
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,035,713.52	976,149.14
1.1.1.03.1 Орлогын албан татвар	926,288.49	765,583.25
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	926,172.99	813,115.46
1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-47,666.85
1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	115.5	134.64
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	61,037.01	164,041.54
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	48,388.03	46,524.35
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	484,186.81	7,359,395.36
1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,100,524.37
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,259,611.55	0.0
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,273,797	2,861,231.05
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	4,273,797	2,531,029.71
1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,140,484.27	2,502,595.5
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	754,254.84	940,061.16
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,066.2	112,436.53
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,251.18	317,995.92
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	146,224.68	103,736.6

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1.1.2.01.1.05 Нормативт зардал	2,000	0.0
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	176,758.3	153,852.6
1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,222	13,634.8
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,810.43	46,582.68
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	631,896.63	814,295.21
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,133,312.74	28,434.21
1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	330,201.34
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	505,714.88	5,474,313.46
1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	374,016.07	793.65
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-374,016.07	-793.65
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	131,698.81	5,473,519.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,446,870.64	2,483,484.31
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,035,713.52	976,149.14
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	926,288.49	765,583.25
1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-47,666.85
1.1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	115.5	134.64
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	61,037.01	164,041.54
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	48,388.03	46,524.35
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	28,080.65	29,297.84
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,609.72	1,582.87
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,697.65	15,643.64
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	146,075.56	1,507,335.17
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	146,075.56	144,149.96
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,110,364.37
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	252,820.84
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,265,081.55	0.0
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,791,422.08	1,834,216.41
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,791,422.08	1,834,216.41
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,654,805.29	1,805,140.2
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,915.71	936,786.4
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,737.75	112,436.52
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,961.18	310,965.92
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	93,741.57	90,763.86
1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	2,000	1,500
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	180,295.3	163,791.9
1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,222	13,634.8
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,547.08	56,425.36
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	134,384.7	118,835.44
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,136,616.79	29,076.21

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	655,448.56	649,267.91
1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	447,569.87	377,094.34
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	447,569.87	377,094.34
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	447,569.87	377,094.34
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-447,569.87	-377,094.34
1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	15,100	120,000
1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-15,100	-120,000
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	192,778.69	152,173.57
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	203,336.03	396,116.72
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	396,114.72	548,290.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,958,898.99	2,958,898.99
2	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,958,898.99	2,958,898.99
3	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,958,898.99	2,958,898.99
4	1.7 Тайлант үеийн үр дүн	5,473,519.81	5,473,519.81
5	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,432,418.8	8,432,418.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	898,837.2	1,120,299.1	(221,461.90)	124.6
11	Татварын орлого	765,337.2	976,149.1	(210,811.9)	127.5
12	Татварын бус орлого	133,500.0	144,149.9	(10,649.9)	108.0
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,508,176.6	2,288,640.2	219,536.43	91.2
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,920,831.0	1,838,438.8	82,392.17	95.7
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,895,680.5	1,815,639.8	80,040.67	95.8
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	929,167.5	936,786.4	(7,618.90)	100.8
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,212.8	112,436.5	1,776.28	98.4
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	331,885.4	310,965.9	20,919.48	93.7
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	98,829.0	82,993.7	15,835.34	84.0
2106	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,500.0	1,500.0	-	100.0
2107	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	193,639.0	190,595.9	3,043.10	98.4

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	15,700.0	13,634.8	2,065.20	86.8
2109	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,366.8	54,091.2	27,275.61	66.5
213	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	129,380.0	112,635.4	16,744.57	87.1
2132	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,150.5	22,799.0	2,351.50	90.7
22	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,500.0	13,500.0	-	100.0
23	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	11,650.5	9,299.0	2,351.50	79.8
6	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	459,645.6	330,201.3	129,444.26	71.8
61	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	127,700.0	120,000.0	7,700.00	94.0
62	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	66.0	62.0	4.00	93.9
	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
65	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.0	30.0	2.00	93.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	42,670.6
1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,670.6
1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	42,670.6
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,393.4
1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	36,393.4
1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,393.4
1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	9,090.2
1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	550.0
1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,753.2
1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	21,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй бөгөөд орон нутгийн тусгай сантай холбоотой залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг дүн **20,000.0** мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 28,217.0 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Албан шаардлага

3.1.1 Тайлант онд ОНХС-аас "Форум зохион байгуулах" арга хэмжээг төлөвлөн 20,000.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр хүндэтгэл хүлээн авалтын зардалд зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална, 4.1.3.үр ашигтай байх, 15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.4. Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.1.2 Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдлийг тулган шалгахад хүүгийн авлагыг тухай бүр сангийн программд бүртгэж хуримтлуулдаг боловч нягтлан бодох бүртгэлийн программд хүүгийн авлага бүртгэдэггүй, зээл төлөлт хийгдсэн үед үндсэн зээлийн авлага, авлагын зээлийн хүүгийн төлбөрийн журналын бичилт хийж байгаагаас санхүүгийн тайланд авлагын үлдэгдэл зөрүүтэй тусгагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "Үнэн зөв байх, 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.3-т Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. .

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хүүгийн авлагыг нөхөж бүртгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан	1	20,000.0			1	20,000.0
Хүүгийн авлага бүртгээгүй	1	0.0			1	0.0
Нийт дүн	2	20,000.0			2	20,000.0

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	5	155,235.9			5	155,235.9
ИТХ	3	8,906.9			3	8,906.9
ЭМТ	1	2,090.0	1	2,090.0		
Хоршоо хөгжүүлэх сан	3	219,370.7			3	219,370.7
ОНХС	1	20,000.0			1	20,000.0
Дүн	13	405,603.5	1	2,090.0	5	403,513.5